



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 03 сарын 16 өдөр

Дугаар A/153

Ховд

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.4 "в", Авто замын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 3 дугаар сарын 14-ний өдрийн 49 дүгээр тушаалаар батлагдсан журмыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Ховд аймгийн Жаргалант сумын доторх авто замын тэмдэг тэмдэглэгээний ажлыг байнгын ашиглалтанд оруулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга:

Ц.Ганданповрон – Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч

Гишүүд:

Б.Ганзориг – Мэргэжлийн хяналтын газрын авто замын хяналтын улсын байцаагч

Ц.Цогтбаяр – Жаргалант сумын Засаг даргын орлогч

Л.Дорждэрэм – Жаргалант сумын Хот тохижуулах газрын дарга

Нарийн бичгийн дарга:

Ц.Сувдаа – Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн зам тээвэр, уул уурхай, хүнд үйлдвэрийн хөгжлийн бодлого хариуцсан мэргэжилтэн

2.Ховд аймгийн Жаргалант сумын хот доторх замын тэмдэг, тэмдэглэгээний ажлыг ажлын даалгаварын дагуу, хуулийн хүрээнд байнгын ашиглалтанд авч ажиллахыг ажлын хэсгийн ахлагч /Ц.Ганданповрон/ – д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ



Zax A/153 Ch
02 00695